

БИНДЭР СУМ



БИНДЭР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.06.23





## БИНДЭР СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР .

### "НЭГ. ХӨГЖЛИЙГ ХҮРТЭХ БИНДЭРЧҮҮД /ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ/

"Биндэр сумын иргэн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй эрүүл амьдарлын хэв маягийг хэвшил болгосон, Монгол эх орныхоо байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ."

- 1.1 Төрөөс батлагдсан хууль, тогтоол, шийдвэрийг ард иргэдэд сурталчилан таниулах, үйл ажиллагааг хүнд сурталгүй, түргэн шуурхай, жигд хүртээмжтэйгээр хүргэнэ.
- 1.2 "Оюунлаг Биндэрчүүд" дэд хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 1.3 "Зөв Монгол хүүхэд" дэд хөтөлбөрийг суманд хэрэгжүүлнэ.
- 1.4 Биндэр сумын ЕБС-ийн 150 хүүхдийн багтаамжтай дотуур байр, гал тогооны барилгыг шинээр барина.
- 1.5 Орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг аймгийн МСҮТ болон Их дээд сургуулиудад бэлтгэнэ.
- 1.6 Биндэр сумын хэмжээнд 200 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулана.
- 1.7 Зайны цахим сургалтаар дээд боловрол эзэмших иргэд залуусын судалгааг гарган боломжийг олгоно.
- 1.8 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах "Зөв дархлаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.9 Спортын клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж улс, аймаг, тив дэлхийн тамирчидыг бэлтгэх нөхцлийг бүрдүүлж дэмжин ажиллана.
- 1.10 СДЭ-ийн эмч, сувилагч, залуу боловсон хүчинүүдийг үе шаттайгаар сургах, мэргэшүүлэх, шаардлагатай нарийн мэргэжлийн тоног төхөөрөмжөөр ханган ажиллана.
- 1.11 Сумын эрүүл мэндийн төвийн барилгыг шинээр барина.



- 1.12 Ахмад настан, тусгай хэрэгцээт иргэдэд /ХБИ/ үйлчилгээ үзүүлэх амралт сувиллын газрыг байгуулан, үйлчилгээний чанарын хяналтыг боловсронгуй болгон үйлчилнэ.
- 1.13 Суманд олон улсын стандартад нийцсэн төрөх эмнэлэг байгуулна.
- 1.14 "Архигүй Биндэрчүүд"дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.15 Гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх , санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.16 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад өрхийг хөнгөлөлттэй нөхцөлөөр амины орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.
- 1.17 Биндэр нутгаа байгальд ээлтэй түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон хөгжүүлнэ.
- 1.18 Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоодын жуулчлыг татах, орон нутаг, өв соёлоо сурталчлах зорилгоор үндэсний "Эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулна.
- 1.19 Нутаг орныхоо нэрийг тив, дэлхий, улсад өндөрт өргөсөн тамирчид, уран бүтээлчид, эрдэмтэд, алдартнуудыг алдаршуулах ажлыг зохион байгуулна.
- 1.20 Сумын нутаг дэвсгэрт оршиж буй түүхийн дурсгалыг эзэнжүүлэн хамгаалж, тооллого бүртгэлийн мэдээллийн санг баяжуулна.
- 1.21 Соёлын төвийн албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлэн үйл ажиллагааны чанарын шинэ төвшинд гаргаж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах
- 1.22 Аялал жуулчлалыг хөгжүүлж, жуулчидыг хүлээн авах зочид буудал, жуулчны бааз байгуулах санаачлагыг бодлогоор дэмжинэ.

## ХОЁР. ӨСӨЛТИЙГ ХҮРТСЭН БИНДЭРЧҮҮД /ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

"Ажлын байр- Биндэрийн хөгжил" чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд , бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

- 2.1 Сумын ИТХ-аар " Ажлын байр-Биндэрийн хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Сумын гадаад харилцааны бодлогын үндсэн дээр эдийн засгийн түншлэл, худалдааны хэлэлцээрүүдийг хийх бодлого баримтална.
- 2.3 Малын гаралтай түүхий эд, арьс ширний болон дайвар бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн болгохыг дэмжин ажиллана.
- 2.4 Төвийн ААН-үүдийг нэгдсэн халаалтанд холбоно.
- 2.5 12 айлын орон сууцыг барьж ашиглалтанд оруулна.
- 2.6 Барилгын материалын орон нутгийн чанартай үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. / блок-тоосго, хайрга, элс, цонх, хаалга,/
- 2.7 Сумын төвийн хог хаягдлын менежментийг боловсронгуй болгоно.
- 2.8 Уул уурхайгүй Лицензгүй сум байна.



- 2.9 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээр жимс жимсгэнэ, зөгийн аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.
- 2.10 Онон голын усыг ашиглан "Биндэрьяа" цэвэр усны үйлдвэр барина.
- 2.11 Орон нутгийн чанартай зам гүүрийг засварлах, шинээр барьж байгуулах ажлыг төр хувийн хэвшлийн боломжит бусад эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.
- 2.12 Спорт заалны барилгыг дуусгана.
- 2.13 Төв дотор хатуу хучилттай замыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

#### **"ГУРАВ.НУТАГТАА ЭЗЭН БИНДЭРЧҮҮД /ЭЗЭН МОНГОЛ /**

"Бие даасан эдийн засагтай, эх орныхоо баялагаас хувь хүртсэн эдийн засгийн хувьд бие даасан, зөв засаглалд тэгш оролцож, түүх өв соёлоо эрэхмлэн дээдэлж нутагтаа эзэн хувь хүнийг төлөвшүүлнэ.

- 3.1 Төрийн худалдан авалтын үйл ажиллагааг орон нутагтаа сонгон шалгаруулдаг, зөвхөн дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг тогтолцоонд шилжинэ.
- 3.2 "Чинээлэг малчин" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.3 Газар тариалангын бус нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариаланчдыг бодлогоор дэмжинэ.
- 3.4 Сумын төвийн гудамжны эмх цэгц, өнгө үзэмжийг бүрэн төгс сайжруулан "Хашаандаа сайхан амьдарья", "Жорлонгоо өөрчлье" дэд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.5 Сумын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.6 Сумын нутаг дэвсгэрт гадны малчидыг малаа оторлох журмыг мөрдүүлэн ажиллана.
- 3.7 Max махан бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулан малыг эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

**ДӨРӨВ: АЮУЛГҮЙ, АМГАЛАН БИНДЭРЧҮҮД /АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ/ Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалын нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдарлын чанарыг сайжруулна.**

- 4.1 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргээх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдарлын чанарыг сайжруулсан байгальд ээлтэй "Ногоон сум" болгоно.
- 4.2 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэнэ.
- 4.3 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг sumaас дэмжиж ажиллана.
- 4.4 Суманд "Ногоон гудамж", "Иргэн бүр-Нэг мод" төслүүдийг хэрэгжүүлэн үр дүнгээр нь урамшуулах ажлыг жил бүр хийнэ.



8488916 XHT1190

4.3 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг сумаас дэмжиж ажиллана.

4.4 Суманд "Ногоон гудамж", "Иргэн бүр-Нэг мод" төслүүдийг хэрэгжүүлэн үр дүнгээр нь урамшуулах ажлыг жил бүр хийнэ.

## ТАВ. ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ ХЭНТИЙЧҮҮД /ХУУЛЬТАЙ МОНГОЛ/

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхитай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.

5.1 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдийг дарамтлах, айлгах бус аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс онцгой анхаарна.

5.2 Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хууль, дүрэм, журмыг тогтвортой ойлгомжтой байх хууль зүйн цогц шинэчлэл хийнэ.

5.3 Татвар, төрийн хяналт шалгалтыг /мэргэжлийн хяналт /иргэн, хуулийн этгээдэд зөвлөх, боломж олгох, дэмжих чиглэлээр шинэчлэн зохион байгуулна.

5.4 Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.

5.5 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, аюулгүй амар тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ авна.

Мөрийн хөтөлбөр хүлээлгэн өгсөн:

Биндэр сумын Ардчилсан намыг төлөөлж

Нам /эвслийн/ нэр



.....  
.....  
.....  
.....

1 э. Мөнх-Овчир

Албан тушаал .....

гарын үсэг .....

Албан тушаал .....

гарын үсэг .....

2020 оны 6 сарын 23 өдөр